Үндэсний аудитын газрын 2016 оны 03 дугаар сарын 24–ний
Өдрийн 512 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

Сонгуулийн тухай хуулийн хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтын хэрэгжилтэд дүгнэлт гаргахтай холбогдуулан УИХ болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдээс Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэлийн аудитын газарт ирүүлэх мэдээлэл

| № | Нам,эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ | Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг хийхдээ төсвийн төсөөллийг баримталсан эсэх | Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай нийцэж буй эсэх /тийм, үгүй/ | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх /холбогдох заалтыг бичих/ | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030-тай нийцэж буй эсэх /холбогдох заалтыг бичих/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМЫН

2016 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

УРИА: МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
МОНГОЛЫН АРД ТҮМЭН НЭГДЭГТҮН

Өнгөрсөн 26 жилийн туршид ардчилал, шинэчлэл, нийгмийн шилжилт нэрийн дор Ард түмэн маань бүхий л алдаа оноонын туршилтын талбар болж, хүнд хүчир бүхнийг нуруун дээрээ үүрч тээсээр ядарч цөхөрлөө.

Ард түмнийхээ тэвчээрийг биширч байна. Аливаад хэмжээ хязгаар, цаг хугацаа гэж бий. Одоо сорьж, туршиж болсоон. АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ.

Хүмүүс итгэл үнэмшилтэй, аливаа айх аюулгүй, гачигдах зовлонгүй амьдрах нь тэдний эрхэм дээд эрмэлзэл мөнийг Ард Түмнээ Хайрлая Нам гүнээ ухамсарлаж байна.

Хүн бүр төрж мэндлэхдээ адилхан нэр төртэй, ижил эрхтэй байдаг. Оюун ухаан, нандин чанар заясан хүн хэмээх бодьгал өөр хоорондоо ахан дүүгийн барилдлага, үзэл санаагаар харьцах учиртай. ХҮН, ХҮНЭЭ ХАЙРЛАЯ.

АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН УХА0122 № 729 2016 он 04 сар

Монгол хүн бүрийг гэдэс цатгалан, мөр бүтэн, дулаан орон гэртэй, бие, сэтгэл эрүүл амгалан амьдруулах нь манай намын нэн даруй хийх ажил, эрхэм үүрэг мөн хэмээн үзэж АРД ТҮМНЭЭ ДЭЭДЭЛСЭН ХҮМҮҮНЛЭГ ЗАСАГЛАЛ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ЭКОЛОГИ-АЮУЛГҮЙ ОРЧНЫ бодлогын хүрээнд:

1. АРД ОЛОНД "А" ЗЭРЭГЛЭЛ ОЛГОХ

2. АЛАГ ҮРСИЙН ТЭТГЭМЖИЙГ ӨСГӨХ

3. АЛИВАА ЗӨВШӨӨРӨЛ, ХУРААМЖИЙГ ХУМИХ

4. АЛАГЧЛАЛГҮЙ ШУДАРГА, ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ

5. АРГА ЯДАРСАНЫГ ХАЛАМЖЛАХ

6. АМЬД МЭНДИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

7. АГААР, ОРЧНЫГ ЦЭВЭРШҮҮЛЭХ

8. АРД ТҮМНЭЭ МӨНГӨЖҮҮЛЭХ эрхэм зорилго бүхий хөтөлбөрөө Ард түмэн – Сонгогч олондоо өргөн толилуулж байна.

| № | Нам,эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ | Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг хийхдээ төсвийн төсөөллийг баримталсан эсэх | Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай нийцэж буй эсэх /тийм, үгүй/ | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх /холбогдох заалтыг бичих/ | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030-тай нийцэж буй эсэх /холбогдох заалтыг бичих/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | **Нэг. Ард түмэн-Хүмүүнлэг шударга засаглал** | | тийм | 5 дугаар зүйлийн 5.1.1- 5.1.7<br>6 дугаар зүйлийн 6.1.2<br>7 дугаар зүйлийн 7.9<br>8 дугаар зүйлийн 8.1<br>9 дүгээр зүйлийн 9.1 | **2.4.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ**<br><br>Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь тогтвортой засаглал мөн. Тогтвортой засаглалыг хангах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын үзэл баримтлал батлан хамгаалах номлолын дагуу улсын тусгаар | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР ... ОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 11 дүгээр зүйлийн 11.1 | тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэртэй хөгжлийг бататгахад оршино.<br><br>**Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим:**<br><br>· төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулж, тогтвортой байдлыг хангах;<br><br>· хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх;<br><br>· удирдлагын ил тод байдлыг хангах;<br><br>· төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах;<br><br>· төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авлигыг арилгах.<br><br>**Зорилт 1.**Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ.<br><br>**Зорилт 2.**Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.<br><br>**Зорилт 3.**Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг | |

МОНГОЛ УЛСЫ
ҮНДЭСНИЙ АУДИТЫ
УХА0122
№ ...
20 16 он 04 сар

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | устгана.<br><br>**Зорилт 4.**Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно. | |
| | 1.1. Ард түмнээ дээдлэх төрт ёсны уламжлал, шударга ёс, тэгш байдлыг тогтоох, хууль ёс дэг журмыг хангах, төрийн албаны сахилгыг чангатгахад чиглэсэн улс төр, эрх зүйн бодлого баримтлана. | | | | **Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим:**<br><br>· төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулж, тогтвортой байдлыг хангах;<br><br>· хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх;<br><br>· удирдлагын ил тод байдлыг хангах;<br><br>· төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах;<br><br>· төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авлигыг арилгах.<br><br>**Зорилт 1.**Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ.<br><br>**Зорилт 2.**Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.<br><br>**Зорилт 3.**Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана. | |
| | 1.2. Аливаа хууль, тогтоомж нь төр, байгууллага, албан тушаалтны эрх ашгийг хамгаалдаг өнөөгийн гажиг бодлогыг халж, хуулийг зөвхөн хүний сайн сайхны төлөө, хүнийг хамгаалахын төлөө батлан гаргах бодлого | | | | мөн адил | |

ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

МОНГОЛ УЛСЫ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН
УХА0122
№ 729
20 16 он 04 сар 07

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлнэ. | | | | | |
| | 1.3. Төрийн захиргааны албыг намаас ангид байж чадах итгэл үнэмшилтэйгээ харуулсан, чадварлаг, эх орон, ард түмний язгуур эрх ашгийг эрхэмлэгч ноён нуруутай, өндөр ёс зүйтэй ард олноор бэхжүүлж, ард түмэнд ил тод, алагчлалгүй, шударга, хүртээмжтэй, хүнд сурталгүй үйлчилдэг, цомхон, мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба болгох шинэтгэлийн бодлого явуулна. | | | | мөн адил | |
| | 1.4. УИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг даргын сонгуульд зөвхөн намууд нэр дэвшүүлдэг одоогийн тогтолцоог өөрчилж иргэний нийгмийн байгууллага, нутаг орны иргэд санал нэгдэн нэр дэвшүүлэх эрхийг хуульчилна. | | | | мөн адил | |
| | 1.5. Сонгогчид УИХ-ыг тараах, гишүүнийг эгүүлэн татах, Засаг даргаа өөрсдөө шууд сонгох, хариуцлага тооцох, эгүүлэн татах, иргэний үндсэн эрхийн хяналтыг Үндсэн хуулийн цэц хэрэгжүүлэх хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ. | | | | мөн адил | |
| | 1.6. Монголын төрийн албыг намынхаа болоод амин хувийнхаа зорилгод ашиглагчдаас ангид байлгана. | | | | мөн адил | |
| | 1.7. Монгол төрийн бодлогын уламжлалыг хадгалсан хүчтэй Ерөнхийлөгчийн засаглалыг дэмжинэ. | | | | мөн адил | |
| | 1.8. УИХ-д төрийн өндөр дээд албан тушаалтнуудын хэргийг шалгах Мөрдөн | | | | | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | шалгах комиссыг байгуулна. | | | | мөн адил | |
| | 1.9. Улс орон, ард түмнийг өр зээлийн барьцаанд оруулсан, улсын эдийн засаг, санхүүгийн нөөцийг шавхан хоосолсон, эх орон, ард түмний язгуур эрх ашигт хохирол учруулсан улс төрийн нам, бүлэглэл, улс төрчдөд хуулийн хариуцлага хүлээлгэнэ. | | | | мөн адил | |
| | 1.10. Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагын төсөв, мөнгө, хүний нөөц, эд хөрөнгийн зохистой эрх мэдлийн тэнцлийг хангасан эрх зүйн орчин бүрдүүлнэ. | | | | мөн адил | |
| | 1.11. УИХ, Засгийн газрын гишүүд болон төр, захиргааны байгууллагын удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх, томилгоо хийхэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ. | | | | мөн адил | |
| | 1.12. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны болон санхүүжилт, зардлын ил тод байдал, үүрэг, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг шинэчлэнэ. | | | | мөн адил | |
| | 1.13. Улс төрийн нөлөөнөөс ангид, хүний эрхийг дээдэлсэн, шударга шүүх эрх мэдлийг төлөвшүүлнэ. | | | | мөн адил | |
| | 1.14. Ард иргэдийг хохироож шүүхээс иргэний болон захиргааны хариуцлага хүлээлгэчихээд шүүхийн шийдвэр биелүүлдэггүй, биелүүлсэн дүр үзүүлж зальддаг, хохирлыг татвар төлөгчдийн, хувь нийлүүлэгчдийн хөрөнгө, мөнгөөр барагдуулдаг албан тушаалтнуудад | | | | мөн адил | |

АЗАР
өдөр

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 ☏ 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | албан тушаалын хариуцлага, нөхөн төлбөр хүлээлгэдэг болгоно. | | | | | |
| | 1.15. Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, ОХУ, БНХАУ-тай стратегийн түншлэлийн харилцаагаа бататган, сайн хөршийн найрсаг харилцааг улам бүр хөгжүүлнэ. | | | | **Зорилт 4.** Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно. | |
| | **Хоёр. Ард түмэн - хүмүүнлэг нийгмийн бодлого** | баримталсан | тийм | 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.7<br>6 дугаар зүйлийн 6.1.2<br>7 дугаар зүйлийн 7.9<br>8 дугаар зүйлийн 8.1<br>9 дүгээр зүйлийн 9.1<br>11 дүгээр зүйлийн 11.1 | **2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ. | |
| | **2.1.** Хүүхэд, залуу үед шинжлэх ухааны мэдлэгтэй хослуулан хүн болох, хүн, хүнээ, эх газар нутаг, унаган байгалиа, түүх соёлын өвөө, уламжлалт хэл, соёл, ёс заншлаа хайрлан хамгаалах, дээдлэх, сурч мэдэх, бүтээлчээр хөгжүүлэхэд чиглэсэн боловсрол эзэмшүүлэх бодлого баримтлана. | | тийм | | **2.2.3.Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн**<br><br>**Зорилт 1**. Хүүхэд бүрийг ... монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ. | |
| | 2.2. Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэд баталгаатай баялаг хоол, хүнсээр үйлчлэх нөхцлийг бүрдүүлсэн хоолны газрыг бий болгох эрх зүйн | | тийм | | **2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь..., иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох.<br>2.2.3.Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий | |

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
УХА0122
№ 729
2016 он 04 сар 27 өдөр

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | орчин бүрдүүлнэ. | | | | Монгол хүн<br>Зорилт 2.Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.<br><br>**I үе шат (2016-2020):** Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд /PISA/ хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхэд бүр мэргэжлийн чиг баримжаатай болсон байх. | |
| | 2.3. Мэргэшсэн ажилтан бэлтгэх, тэднийг үйлдвэрлэлтэй холбоход чиглэсэн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ. | | тийм | | **Зорилт 3.**Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ.<br><br>**I үе шат (2016-2020):** Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлж, суралцагчдын тоог 60.0 мянгад хүргэх. | |
| | 2.4. Өнөөгийн төрийн бодлогын гадна буй шинжлэх ухааны салбарын ач холбогдлыг онцгойлон үзэж дэмжинэ. | | тийм | | **Зорилт 5.**Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ.<br><br>**I үе шат (2016-2020):** Инновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь хүртэлх түвшинд хүргэх. | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 ... 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2.5. Хүн бүрийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй, чирэгдэлгүй оношлогоо, эмчилгээ, үйлчилгээнд хамруулах явдал нь эрүүл мэндийн салбарын эрхэм зорилго хэмээн үзнэ. | | тийм | | **2.2.2.Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоо**<br><br>**Зорилт 1.**Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.<br><br>**I үе шат (2016-2020):** Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 71-д хүргэх.<br><br>**Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>•эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байх; | |
| | 2.6. Эмнэлэгийн орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг хангаж, хүн бүрт эрүүл мэндийн үйлчилгээний дэвшилтэт ололтыг хямд хүртээж эх орондоо эмчлэгдэх нөхцлийг бүрдүүлнэ. | | тийм | | мөн адил | |
| | 2.7. Хүн ардад ажил, амьдралын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, агаар, хөрс, усны бохирдолтоос болж эрүүл мэндээр хохирогсдын хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ. | | тийм | | мөн адил | |
| | 2.8. Ард түмний алтан амийг авардаг, алаг үрсийн амьдралын замын эхийг тавьдаг ачит эмч, багш, нарыгаа амьдралд нь хүрэлцэхүйц цалин хөлстэй сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах боломжийг бүрдүүлэх нь | | тийм | | **2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>· Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой | |

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН Г
УХА0122
№ 729
2016 он 04 сар
УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | боловсролын салбарын бодлогын тэргүүн зэргийн зорилт гэж үзнэ. | | | | тоглолцоонд шилжүүлэх; | |
| | 2.9. Хүнээ хамгаалах, хүн амаа өсгөх, хүний хөгжлийг хангах, хүнээ халамжлахад чиглэсэн нийгмийн цогц бодлого явуулна. | | тийм | | **2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>· хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүртээмжтэй өсөлтөд суурилсан хүний хөгжил байх;<br><br>· иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх;<br><br>· эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байх;<br><br>· хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд байлгах;<br><br>· нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх;<br><br>· нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх;<br><br>· нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх;<br><br>· хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх. | |
| | 2.10. Хүүхэд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд зэрэг зорилтот бүлгийг дэмжих бодлого явуулж, нийгмийн халамжийн тусламж, тэтгэврийг | | тийм | | **2.2.1.Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал**<br><br>**Зорилт 1.Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.**<br><br>**I үе шат (2016-2020):** Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР ХОЁР МОНГОЛЫН ҮРСИЙГ ... ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тогтвортой өсгөх бодлого хэрэгжүүлнэ. | | | | чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулах. | |
| | 2.11. Хүн амын өргөн хэрэглээний гол нэр төрлийн бараа, үйлчилгээний /гурил, будаа, мах, сүү, шатахуун, эрчим хүч, дулаан гэх мэт/ үнийг төрөөс зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ. | | тийм | | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. | |
| | 2.12. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, цагийн хөлсний хэлбэрийг нэвтрүүлэх, дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлэх, орлого багатай хэсгийг тэтгэж дундаж орлоготны эгнээнд хүргэх бодлого явуулна. | | тийм | | **2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь ... зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.<br><br>**Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>· нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх;<br><br>· хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх. | |
| | 2.13. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүн бүрийг гэрээ, хэлэлцээрээр цалин хөлс, хангамжаа нэмэгдүүлэх, ажлын байраа тогтвортой хадгалах, хөдөлмөрийн мөлжлөгт орохоос хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | | тийм | | **2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь ... зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.<br><br>**Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>· Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоонд шилжүүлэх; | |
| | 2.14. Гэр хорооллыг төвлөрсөн дулаан, цэвэр, бохирын шугамд холбох замаар инженерийн байгууламж бүхий амины орон сууцны хороолол бий болох нөхцөлийг бүрдүүлнэ. | | тийм | | **2.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Байгаль орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн суурь, хүний амьдралын чанарыг | |

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН
УХА0122
№ 7...
20 16 он 04 сар

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжруулах үндэс болно.<br><br>**Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>· цэвэр технологийг дэмжих, хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төлөвшүүлэх;<br><br>**Зорилт 2.** Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна. | |
| | 2.15. Хүн амын төвлөрөл бүхий хот, суурин газар бүрт усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэл хийх нь ард түмний амьд мэндийн баталгааг хангах найдвартай үндэс гэж үзнэ. | | тийм | | **2.1.5.Дэд бүтцийн салбар**<br><br>**Зорилт 6.** Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.<br><br>**I үе шат (2016-2020):** Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах. | |
| | **Гурав. Ард түмэн - хүмүүнлэг эдийн засгийн бодлого** | баримталсан | тийм | 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.7<br>6 дугаар зүйлийн 6.1.2<br>7 дугаар зүйлийн 7.9<br>8 дугаар зүйлийн 8.1<br>9 дүгээр зүйлийн 9.1<br>11 дүгээр | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ. | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | зүйлийн 11.1 | | |
| | 3.1. Түүхий эдийг дотооддоо боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн гаргах бодлого хэрэгжүүлнэ. | | тийм | | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ.<br><br>**2.1.3.Аж үйлдвэрийн салбар**<br><br>**Зорилт 1.** Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.<br><br>**I үе шат (2016-2020):** Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх.<br><br>**2.1.4.Эрдэс баялгийн салбар**<br><br>**Зорилт 2.** Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. | |
| | 3.2. Байгальд ээлтэй, өрсөлдөх чадвартай үйлдвэржилтийн бодлогыг дэмжинэ. | | тийм | | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим:**<br><br>**Салбарын хөгжлийн зорилтыг хангах зарчим:**<br><br>· өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах;<br><br>· байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэлийг дэмжих; | |

МОНГОЛ УЛС... ҮНДЭСНИЙ АУДИТ...
УХА0122
№ 7..
20 18 он 04 сар

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ИХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3.3. Ард олны жижиг дунд бизнесийг жинхэнэ утгаар нь тэгш, шударгаар дэмжиж, тогтвортой ажлын байр бий болгоно. | | тийм | | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**2.1.1.Хөдөө аж ахуйн салбар**<br><br>**Зорилт 4.** Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.<br><br>**I үе шат (2016-2020):** Малчин, тариаланчдын 50 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх.<br><br>**2.2.1.Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал**<br><br>**Зорилт 2.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.<br><br>**I үе шат (2016-2020):** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүргэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 100 тэрбумаас доошгүй төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх. | |
| | 3.4. Үр ашиг муутай хөрөнгө оруулалт, төрийн захиргааны албаны зардлыг эрс багасгах замаар дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн зардлын эзлэх хувийг бууруулна. | | тийм | | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим:**<br><br>· төсвийн тэнцлийн зохистой харьцааг чанд баримтлах, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн нийт зарлага /улсын нэгдсэн төсөв болон Хөгжлийн банкны санхүүжилтийг бүхэлд нь тооцсоноор/-ыг 2020 | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | онд 35 хувь, 2030 онд 30 хувь хүртэл бууруулах;<br><br>**2.1.6.Макро эдийн засгийн бодлого**<br><br>**Зорилт 1.** Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна.<br><br>**I үе шат (2016-2020):** Улсын төсвийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас ихгүй байхаар төлөвлөх. | |
| | 3.5. Хүн ардын **эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллад** түлхүү чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ. | | тийм | | **2.1.6.Макро эдийн засгийн бодлого**<br><br>**Зорилт 1.** Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна.<br><br>**2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь ... бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.<br><br>**Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>· хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүртээмжтэй өсөлтөд суурилсан хүний хөгжил байх;<br><br>· иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх;<br><br>· эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан | |

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫ
УХА0122
№ 729
20 16 он 04 сар

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
...РИЙН ХҮЧИН ДОР
...ОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байх;<br>· нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх;<br>· нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх;<br>· хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх. | |
| | 3.6. Монгол түмний гэрэлт ирээдүй болсон алаг үрсдээ зориулан "Хүний хөгжил сан"–гаас олгодог тэтгэмжийг тасралтгүй өсгөх бодлого баримтлана. | | тийм | | **2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br>**Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br>· хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүртээмжтэй өсөлтөд суурилсан хүний хөгжил байх; | |
| | 3.7. Нэмэгдсэн өртгийн албан татварыг тэглэж, хүн амын орлого багатай хэсгийг орлогын албан татвараас чөлөөлнө. | | тийм | | **2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br>Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь ... ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.<br>2.2.1.Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал<br>**Зорилт 1.**Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.<br>**I үе шат (2016-2020):** Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулах. | |
| | 3.8. Банкуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, монополь байдлыг халах, хүү багатай зээл олгох, монгол хүний эрх ашигт нийцсэн хүү багатай гадаад эх үүсвэрийг татах, зээлийн хүүгийн дээд хязгаарыг төрөөс хянаж, зохицуулах бодлого хэрэгжүүлнэ. | | тийм | | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br>**Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим:**<br>· банк, санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой, эрсдэлгүй, найдвартай байдлыг чанд хангаж, хөгжлийн бодлогын зорилтод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх;<br>· урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллах. | |
| | 3.9. Ард олноос газрыг харамладаг, газраас нь хөөдөг, хавчдаг, газрыг нь луйвардаг бусармаг үйлдлийг таслан зогсооно. | | тийм | | **2.1.5.Дэд бүтцийн салбар**<br><br>**Зорилт 6.** Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.<br><br>**I үе шат (2016-2020):** Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах. | |
| | 3.10. Ард түмэнд амьдрах орон гэрээ барих, бизнес эрхлэх зориулалтаар газрыг жинхэнэ утгаар нь тэгш, шударгаар нэн даруй өмчлүүлэх, эзэмшүүлэх, үр ашгийг нь түргэн хүртэх газрын шинэтгэл, дахин хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ. | | тийм | | мөн адил | |
| | 3.11. Монгол орны бүхий л баялаг, нөөц, боломж, үр өгөөжтэй бүхнийг нээн илрүүлж Ард түмний тусын тулд зориулан Ард түмэн Монгол улсын жинхэнэ эзэд юм байна гэдгийг мэдрүүлнэ. | | тийм | | **2.4.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ**<br><br>**Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим:**<br><br>· хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх;<br><br>· удирдлагын ил тод байдлыг хангах;<br><br>· төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах;<br><br>· төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авлигыг арилгах.<br><br>**Зорилт 1.**Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих | |

МОНГОЛ УЛСЫ
ҮНДЭСНИЙ АУДИТЫ
УХА0122
№ 709
20 16 он 04 сар

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ.<br><br>**Зорилт 2.**Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.<br><br>**Зорилт 3.**Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомжийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.<br><br>**Зорилт 4.**Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно. | |
| | 3.12. Төрийн өмчит хуулийн этгээдийг үнэгүйдүүлэн зальт аргаар хувьчилж авсан үйлдлийг илрүүлэх, хувьчлахаар гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, цаашид эрчим хүч, агаарын болон төмөр замын тээвэр, харилцаа холбоо зэрэг стратегийн томоохон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн статусыг хэвээр байлгах, улмаар архи, спирт, тамхи, казино зэрэг төрийн өмчит монополийг бий болгох бодлого явуулна. | | тийм | | мөн адил | |
| | 3.13. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг устгаж, бүртгэлийн тогтолцоонд шилжүүлж төрийн хүнд суртал, авилгыг таслан зогсооно. | | тийм | | мөн адил | |
| | 3.14. Эрдэс баялагийн тусгай зөвшөөрөл авч, түүнийгээ бусдад худалдаж олсон орлогод татвар ногдуулах, өмнө нь эрх мэдэл, арга заль, луйвараар зөвшөөрөл авч, олсон орлогод ногдох татварыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ. | | тийм | | мөн адил | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
[illegible]89132 [illegible] 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3.15. Алтыг нь аваад авдрыг нь хаядаг, эздийг нь хөөгөөд ээзн суудаг, цүнх, цүнх мөнгөөр цэлмэг хөх Монголыг маань зардаг хүний, өөрийн зальхай этгээдүүдийн савраас эх орноо татан авч Ард түмнээ эх нутагт нь ЭЗЭН суулгана. | | тийм | | мөн адил | |
| | 3.16. Ард түмний татварын хөрөнгөөр нөөцийг нь тогтоосон ордуудыг төрийн мэдэлд авч, байгальд ээлтэй дэвшилтэт технологийн дагуу олборлолт явуулж үр өгөөжийг нь монгол хүн нэн тэргүүнд хүртэх бодлого баримтлана. | | тийм | | мөн адил | |
| | 3.17. Нефть бүтээгдэхүүний импорт, бөөний худалдааг төрийн мэдэлд авч, цахилгаан, дулаан, нефть бүтээгдэхүүний үнийг улс даяар нэг төвшинд байлгах бодлого хэрэгжүүлнэ. | | тийм | | мөн адил | |
| | 3.18. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд экспортын орлогоо монголын банкуудаар дамжуулан гүйцэтгэж санхүүгийн тайлан тэнцлээ монгол хэлээр, монгол төгрөгөөр гаргадаг байх журмыг хатуу мөрдлөг болгоно. | | тийм | | мөн адил | |
| | 3.19. Малын гоц халдвар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, үйлчилгээнд төсвөөс гаргадаг хөрөнгийг тогтвортой өсгөж, мал сүргээ бүрэн эрүүлжүүлэх бодлого баримтлана. | | тийм | | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**2.1.1.Хөдөө аж ахуйн салбар**<br><br>**Зорилт 1.**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх | |

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН Г
УХА0122
№ 729
2016 он 04 сар 27

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.<br><br>**I үе шат (2016-2020):** Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай нутгийн хэмжээг нийт газар нутгийн 10-аас доошгүй хувьд хүргэж, мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргах мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчинг бүрдүүлж, үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоог боловсронгуй болгох. | |
| | 3.20. Аймагуудад малыг зах зээлийн үнээр худалдан авах, нядлах, мах, малын гаралтай түүхий эд, ноос, ноолуур, арьс шир боловсруулах олон улсын стандарт хангасан үйлдвэр, мах нөөцлөх зориулалт бүхий агуулах, бөөний худалдааны төвүүдийг байгуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг үнийн огцом уналтаас сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ. | | тийм | | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**2.1.1.Хөдөө аж ахуйн салбар**<br><br>**Зорилт 2.**Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ.<br><br>**I үе шат (2016-2020):** Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг гурван хувьд хүргэж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог 100.0 мянган толгойд хүргэх, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулан, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд бий болгох. | |
| | 3.21. Мал аж ахуйг эрчимжүүлж, малын эрүүлжүүлэлтийг олон улсын стандартад хүргэж, мал аж ахуйн гаралтай бүтээгдхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлого баримтална | | тийм | | Мөн адил | |
| | 3.22. Улаанбуудай, хүнсний ногооны импортын хэрэглээг хязгаарлаж, тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуй, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх замаар дотоодын хэрэгцээг бүрэн хангана. | | тийм | | **2.1.1.Хөдөө аж ахуйн салбар**<br><br>**Зорилт 3.** Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс толдох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ. | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **I үе шат (2016-2020):** Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг элдэншүүлэлтийн технологи нэвтрүүлэх ажлыг 70 хувьд, усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 65.0 мянган га-д, жилд шаардагдах бордооны хангамжийг 50 хувьд, нутагшсан сортын элит үрийн хангамжийг 75 хувьд тус тус хүргэн, тариаланд ашиглагдаж байгаа талбайн хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлж, элэгдэл, эвдрэлийг саарулах. | |
| | 3.23. Газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, тос боловсруулах үйлдвэр байгуулах, нүүрснээс хий, шингэн түлш гарган энэ төрлийн бүтээгдэхүүний гадаад хамаарлаас ангижрах бодлого баримтлана. | | **тийм** | | **2.1.3.Аж үйлдвэрийн салбар**<br><br>**Зорилт 3.** Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.<br><br>**I үе шат (2016-2020):** Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх. | |
| | 3.24. Орхон, Дархан-Уул, Хөвсгөл зэрэг аймгуудын хөгжлийг түргэтгэх цогц бодлого хэрэгжүүлнэ. | | **тийм** | | **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-химийн, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ. | |
| | **Дөрөв. Ард түмэн – хүмүүнлэг байгаль экологи, аюулгүй орчны бодлого** | | **тийм** | 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.7<br>6 дугаар зүйлийн 6.1.2<br>7 дугаар зүйлийн 7.9<br>8 дугаар зүйлийн | **2.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>Байгаль орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн суурь, хүний амьдралын чанарыг сайжруулах үндэс болно.<br><br>**Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>• байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах; | |

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫ
УХА0122
№ 70
20 16 он 04 сар

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 8.1<br>9 дүгээр зүйлийн<br>9.1<br>11 дүгээр зүйлийн 11.1 | • байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах;<br><br>• цэвэр технологийг дэмжих, хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төлөвшүүлэх;<br><br>• байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартын түвшинд хийж, хэвшүүлэх;<br><br>• байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх. | |
| | 4.1. Цэвэр онгон байгалиа хойч үедээ өвлүүлэн үлдээх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, ард олон газар нутгаа зохистойгоор эзэмшиж үр шимийг нь шударгаар хүртэх бодлого баримтлана. | | тийм | | **2.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**2.3.3.Экосистемийн тэнцвэрт байдал**<br><br>**Зорилт 1.** Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.<br><br>**I үе шат (2016-2020):** Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх. | |
| | 4.2. Ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчин, хууль бус мод бэлтгэлээс хамгаалах, нөхөн сэргээх, мод орлох технологийг нэвтрүүлэх чиглэлээр бодлогын шинэчлэл хийнэ. | | тийм | | **2.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>· байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах;<br><br>· цэвэр технологийг дэмжих, хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төлөвшүүлэх;<br><br>· байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартын түвшинд хийж, хэвшүүлэх;<br><br>· байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх. | |
| | 4.3. Ард түмний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх цацраг идэвхит болон химийн хорт | | тийм | | **2.3.2.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох**<br><br>**Зорилт 2.** Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн | |

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР МОНГОЛЫН ҮРСИЙГ ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бодисын хэрэглээг багасгах, хязгаарлах, хор хөнөөл ихтэй уурхай, үйлдвэрийг эдийн засгийн үр ашгийг харахгүйгээр шууд хаах бодлого баримтлана. | | | | ялгарлыг бууруулна.<br><br>**I үе шат (2016-2020):** Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, нүүрс, занарыг шингэрүүлэх, хийжүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 2 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлэх. | |
| | 4.4. . Уул уурхай, бусад байгалийн баялагийн нөхөн сэргээлт хийгээгүй иргэн, аж ахуйн нэгжид ногдуулах хариуцлагыг чангатгах, байгаль орчинд хохирол учруулсан талаархи бодитой мэдээлэлийг урамшуулах, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоох эрх зүйн орчин бүрдүүлж хүн ардын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгоно. | | тийм | | **2.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**<br><br>**Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах зарчим:**<br><br>· байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах;<br><br>· байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартын түвшинд хийж, хэвшүүлэх; | |
| | 4.5. Ашигт малтмалыг хайх, олборлох, газар, бэлчээрийг эзэмших, өмчлөх эрх гагцхүү ард түмний бүрэн мэдэлд байж, газар болон газрын хэвлийн баялгийг зөвхөн Монгол хүнээр дамжиж эзэмших, ашиглах эрх зүйн орчин бүрдүүлнэ | | тийм | | **2.4.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ**<br><br>**Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим:**<br><br>• хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх;<br>Зорилт 1.Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ. | |
| | 4.6. Цөлжилтийг зогсоох, бэлчээрийн хэт талхагдлыг бууруулах, устах аюулд орж байгаа амьтан, ургамлаа хамгаалах ажлыг ард иргэдийнхээ санаачлага, дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэгт тулгуурлан монгол төрийн бодлогын тэргүүн эгнээнд тавина. | | тийм | | **2.3.3.Экосистемийн тэнцвэрт байдал**<br><br>**Зорилт 1.** Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.<br><br>**I үе шат (2016-2020):** Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх. | |
| | 4.7. Усны нөөцийн ашиглалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэл болон ахуйн хэрэгцээнд гадаргын усны нөөц, | | тийм | | **2.3.1.Усны нөөцийн нэгдсэн менежмент**<br><br>**Зорилт 1.**Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос | |



МОНГОЛ УЛ... ҮНДЭСНИЙ АУДИТ... УХА012... № 72... 20 16 он 04 сар...
УЛААНБААТАР ХОТ АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ ... ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ 8489132 1115208525

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | илүүдэл ус (шар усны үер)-ыг ашиглах, хот, суурин газрын болон уул уурхайн үйлдвэрлэлийн бохир усыг цэвэршүүлэх, эргүүлэн ашиглах бодлого хэрэгжүүлнэ. | | | | сэргийлнэ.<br><br>**I үе шат (2016-2020):** Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх. | |
| | 4.8. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цөмийн хаягдал булшлах, энэ талаархи олон улсын конвенцид нэгдэхийг хатуу хориглоно. | | тийм | | **2.4.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ**<br><br>Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь тогтвортой засаглал мөн. Тогтвортой засаглалыг хангах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын үзэл баримтлал, батлан хамгаалах номлолын дагуу улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэртэй хөгжлийг бататгахад оршино.<br><br>**Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим:**<br><br>• хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх;<br>**Зорилт 1.**Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ. | |
| | 4.9. Химийн болон генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлэх хүчин чадварыг бүрдүүлж, гаднаас оруулах, хэрэглэхийг хуулиар хориглоно. | | тийм | | **2.1.3.Аж үйлдвэрийн салбар**<br><br>**Зорилт 1.**Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.<br><br>**Зорилт 2.**Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ. | |
| | 4.10. Хүнсний аюулгүй байдлын стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, мөнхүү шаардлагад нийцсэн тээвэр, агуулахын сүлжээ, ложистик байгуулах бодлого хэрэгжүүлнэ. | | тийм | | **2.1.5.Дэд бүтцийн салбар**<br><br>**Зорилт 3.**Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ. | |

ЫН
ЫН ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ
АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ
8489132 1115208525

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
УХА0122
№ 729
2016 он 04 сар 27 өдөр

МОНГОЛЫН АРД ТҮМНИЙГ, МӨНХ ТЭНГЭР ИВЭЭГ!!!

Жич:
- 2 дугаар баганад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тооцоолохдоо төсвийн төсөөллийг баримталсан эсэх /2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль/
- 4 дугаар баганад холбогдох хуулийн ямар заалтыг үндэслэл болгосныг тодорхой бичнэ.
- 5 дугаар баганад Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын ямар заалтыг үндэслэл болгосныг тодорхой бичнэ.

МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭСЭН:

АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМЫН ДАРГА Л. ГҮНДАЛАЙ

АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМ
МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР
ХӨХ МОНГОЛЫН ҮРСИЙГ
ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН ИВЭЭГ

2016 оны 04 сарын 18-ний өдөр

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.27 № 429

танай ____________-ны № ____________-т

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Ард түмнээ хайрлая намын "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

***Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл***

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

***Дүгнэлтийн үндэслэл***

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Ард түмнээ хайрлая намаас ирүүлсэн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

***Дүгнэлт***

Ард түмнээ хайрлая намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Ард түмнээ хайрлая намд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР А.ЗАНГАД

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0425NAG104.Docx

073827